

“Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн
Мэдээлэл

д/д	Баримт бичгийн нэр	Хуудасны тоо
1	Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ	1
2	Компанийн дүрэм	3
3	Төлөөлөн удирдах зөвлөл байгуулсан хурлын тогтоол	1
4	Төсөвт бүрдүүлсэн татвар, нийгмийн даатгал шимтгэл төлсөн хэмжээ	1
5	Удирдлагын Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг хянасан тухай	1
6	Удирдлагын ажилд томилсон тушаал	1
7	Компанийн Удирдлагын мэдээлэл	1

Компанийн удирдлагын мэдээлэл

д\д	Овог нэр	Нэр	Цалин хөлс	Урамшуулалын дүн	Ажлын газрын хаяг,	Ажлын цахим шуудангийн хаяг
1	Банзрагч	Одхүү	1,500,000	Байхгүй	Анхдагч-125-р байр,	Khugjliin.ireedui2021@gmail.com

**"Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй"
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХКомпанийн эрхзүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, хяналтын тогтолцоо, санхүү бүртгэл тэдгээрийн эрх зүйн харилцааны үндсэн баримт бичиг мөн.

1.2. Компанийг үүсгэн байгуулагч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

1.3. "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХКомпани (цаашид "компани" гэх) нь Монгол улсын "Иргэний хууль", "Компаний тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Хөдөлмөрийн тухай хууль", "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн дагуу "Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани" хэлбэрээр ажиллана.

1.4. Дүрмийн зорилго нь дүрмээр тогтоогдсон эрх зүйн харилцааны хүрээнд аж ахуйн үйл ажиллагаагаар хуримтлал үүсгэх, ашгийн төлөөх үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулахад оршино.

1.5. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3, 19-р зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллана.

1.6. Аймгийн Засаг дарга нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гаргасан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэйгээс гадна Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29, 30-р зүйл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Компанийн оноосон нэр, оршин байгаа газар

2.1. Үйлдвэрийн газрын оноосон бүрэн нэр нь "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" товчилсон нэр нь "ХАА-ХИ" ОНӨХХК байна.

2.2. Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Булган аймгийн Булган сумын 5 дугаар баг

2.3. Үйлдвэрийн газрын шуудангийн хаяг: Монгол улс, Булган аймаг, Булган сум

2.4. Электрон шуудангийн хаяг: ХАА-hugjil bulgan@yahoo.com

Гурав. Компанийн бэлгэдэл, тамга, тэмдэг

3.1 "Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй" ОНӨХХКомпани нь өөрийн бэлгэдэл тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2 Бэлгэдэл, тамга, тэмдгийн загварыг захирал баталж, Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг компани эдэлнэ.

3.3 Тамга, тэмдэгээр албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4 Тамга, тэмдгийг компанийн захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, эшиглалт, хадгалалт, хамгаалтыг хариуцна.

4.3.3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах бол ТУЗ-д танилцуулж гарсан саналыг тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулан улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

4.3.4. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр компанийг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Тав. Компанийн эд хөрөнгийн эрх

5.1. Компани нь аймгийн ИТХ-аас шилжүүлэн өгсөн өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдлэж, хариуцлага хүлээнэ.

5.1.1. Компани нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна.

а. Өөрт олгогдсон өмчлөлийн эрхийн хүрээнд үндсэн болон хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах, ашиглалтыг сайжруулах, түрээслэх

б. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

в. Компаний үйл ажиллагааны үр дүнд бий болсон хуримтлал болон ашгийг ТУЗ-ийн хуралд тайлагнаж, бизнес хөгжлийн төлөвлөгөө, цаашид авах арга хэмжээний саналаа танилцуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн тогтоолоор зарцуулах эрх үүснэ.

г. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.

д. Компани нь үндсэн болон эргэлтийн хөрөнгийг Засгийн газрын холбогдох тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн худалдан авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

Зургаа. Компанийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Төлөөлөн удирдах зөвлөл:

6.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийг /цаашид ТУЗ гэх/-ийг 7-9 гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр аймгийн ИТХ-аас байгуулах бөгөөд компаний гүйцэтгэх захиралд чиглэл өгөх, зөвлөн туслах, хэлбэрээр ажиллана.

6.1.2. ТУЗ нь үүсгэн байгуулагчийн, орон нутгийн өмчийн харилцааны, компаний ажиллагааны чиглэлийн дагуух мэргэжлийн бодлого зохицуулалтын байгууллагын төлөөлөл оролцуулсан гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

6.1.3. ТУЗ нь компаниас ирүүлсэн саналыг үндэслэн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, актлах талаар хэлэлцэн санал дүгнэлтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, шийдвэр гаргуулах

6.1.4. Компанийн үйл ажиллагааны болон худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих

6.1.5. Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх саналаа аймгийн Засаг даргад өргөн барих

6.1.6. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох, шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоосон гэрээний нөхцлийг тогтоож, гэрээг байгуулж аймгийн Засаг даргад өргөн барьж батлуулах /контрактын гэрээ/, гэрээг дүгнэх

6.1.7. Компанийн өмчлөл бүхий үндсэн болон эргэлтийг хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгжид түрээслэх журмыг батлах, мөрдүүлэх

6.1.8. Үндсэн болон эргэлтийн хөрөнгө түрээслэх журам, түрээсийн төлбөрийн хувь хэмжээ, түрээсийн болон эргэн төлөлтийн гэрээний загварыг батлах, мөрдүүлэх

6.1.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах,

6.1.10. ТУЗ-ийн даргыг гишүүдийн хурлаас олонхийн саналаар сонгоно.

6.1.11. ТУЗ-ийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах зардлыг компаний тухайн жилийн төсөвт тусгана.

6.1.12. Компанийн төлөвлөгөөнд тусгагдсан ТУЗ-ийн санхүүгийн эх үүсвэрийг ТУЗ-ийн хурлын тогтоолоор зарцуулж компанийн санхүүгийн тайланд тусгана.

6.1.13. Хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

6.2. Гүйцэтгэх захирал

6.2.1. Компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдана

6.2.2. Гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн санал болгосноор аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.2.3. Томилогдох этгээд дор дурдсан шаардлага хангасан байвал зохино. Үүнд:

- Дээд боловсролтой
- Удирдах ажил хийж байсан зохих дадлагатай
- Удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.

6.2.4. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, удирдаж байсан хуулийн этгээдээ дампууруулсан, эсхүл удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс өөрчлөгдсөн этгээдийг 5 жилийн дотор захирлаар томилохыг хориглоно.

6.2.5. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.3. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрхт, үүрэгтэй байна.

6.3.1. Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох;

6.3.2. Компанийн бизнесийн, стратегийн, үйл ажиллагааны, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах

6.3.3. Компаний зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалингийн санг ТУЗ-өөр батлуулах.

6.3.4. Батлагдсан цалингийн санд багтаан албан хаагчдын цалинд өөрчлөлт хийх

6.3.5. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох

6.3.6. Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг ажилтан албан хаагчдаар хэлэлцүүлэн захирал батлаж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

6.3.7. Түрээсийн болон эргэн төлөлтийн гэрээний загвар, үндсэн болон эргэлтийн хөрөнгө түрээслэх журам, үр дүнгийн урамшуулал олгох журмуудыг боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж тогтоолоор баталгаажуулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

6.3.8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

6.3.9. Эргэн төлөлт, түрээсийн орлого, ашиг хуримтлалаас тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөө болон үйл ажиллагааны зардлыг хасч үлдэх хэсгийг ТУЗ-ийн шийдвэрээр захиран зарцуулах

6.3.10. Маргаантай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох

6.3.11. Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон холбогдох бусад эрх зүйн баримтын хэрэгжилтийн хангахын тулд тэдгээрт нийцсэн тушаал, заавар гаргах

6.3.12. ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан журмын дагуу үндсэн болон эргэлтийн хөрөнгийг түрээслэх гэрээг батлах, биелэлтэнд хяналт тавих

6.3.11. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах

6.3.12. Компанийн эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах

6.3.13. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх

6.3.14. Компанид шинээр худалдан авах болон акталж, устгах, худалдах, шилжүүлэх хөрөнгийн асуудлыг ТУЗ-д танилцуулж тогтоол гаргуулж, ОНӨГ-аар дамжуулан аймгийн ИТХ-аар шийдвэр гаргуулах

6.3.15. Гүйцэтгэх захирал өөрийн эрх, үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.3.16. Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг

Долоо. Хяналтын зөвлөл, үйлдвэрийн газрын хяналт

7.1. Компани нь хяналтын зөвлөлтэй байх бөгөөд 3 гишүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн гишүүдийг ТУЗ-өөс 2 жилийн хугацаатайгаар сонгож батална.

7.2. Хяналтын зөвлөл нь компанийн дүрэм, ТУЗ-өөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үйлдвэрийн газрын удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж ТУЗ-ийн хуралд танилцуулна.

7.3. Хяналтын зөвлөлийн гишүүд нь тус үйлдвэрийн газрын болон бусад аж ахуйн нэгжтэй холбоотой санхүүгийн болон удирдлагын ашиг сонирхолтой байж болохгүй.

7.4. Компани нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байж болно. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг гүйцэтгэх захирал батална.

Найм. Компаний санхүү, бүртгэл, тайлан

8.1. Компаний санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргана.

8.2. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. Компаний санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно

8.4. Нягтлан бодогчийг гүйцэтгэх захирал томилно.

8.5. Санхүүгийн жилийн тайланд баталгаажилт хийлгэх, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.6. Түрээсийн харилцаа, өмч хөрөнгө, санхүүтэй холбоотой ашиглан, шамшигдуулалтын үйл ажиллагаанд компаний санаачилгаар бүрэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг ОНӨГ, санхүү, аудитийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

Ес. Компанийн санхүүжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

9.1 Компани нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1. Улс, орон нутгийн төсвийн санхүүжилт

9.1.2. Ажил үйлчилгээ эрхэлсний орлого / түрээсийн төлбөр, эргэн төлөлт, үр бордоо, мал, мах, хадлан тэжээл худалдан борлуулсан /

9.1.3. Бусад / арилжааны банк бусад санхүүгийн эх үүсвэрээс зээл авах /

9.2. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

9.2.1. Баланс

9.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин, шагнал урамшуулал;

9.2.6. Санхүүгийн тайлант жил дэх эргэн төлөлт, түрээсийн орлого, ашиг хуримтлалыг тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөө болон үйл ажиллагааны зардлыг хасч үлдэх хэсгийн ТУЗ-ийн шийдвэрээр захиран зарцуулах

9.2.7. Нэмэлт тайлбар;

9.2.8. Санхүүгийн тайлангийн тодруулга;

9.2.9. Бусад; Гүйцэтгэх захирал ТУЗ, аймгийн ИТХ болон Засаг даргад тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан, илтгэх бичиг хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

а. Тайлангийн хугацаанд компаний эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

б. Тайлангийн хугацаанд компаний албан тушаалтан, ажиллагсдад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;

в. Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар

Арав. Компанийн бичиг баримтыг хадгалах

10.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгална:

10.1.1 Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, үйлдвэрийн газрыг байгуулах тухай холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд

10.1.2 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд

10.1.3 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

10.1.4 Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримтууд

10.1.5 Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэрүүд;

10.1.6 Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд;

10.2. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэх захирлын туслах, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Арван нэг. Компанийг татан буулгах

11.1. Компанийг хувьчлах, өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаа нь Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдана

Арван хоёр . Бусад асуудал

12.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

12.2. Компанийн энэхүү дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

----oOo----



**БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 01-ны өдөр

Дугаар 13

Булган

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "ж", 20 дугаар зүйлийн 20.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 97 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Шинэ хөдөө-хөгжил" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдврийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

- С.Гал-Эрдэнэ /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/
- М.Бадам /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/
- Ж.Гансүх /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/
- П.Лхагва-очир /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/
- Д.Жаргалсайхан /Аймгийн Засаг даргын орлогч/
- Ч.Амгалан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/
- Э.Уянга /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/
- С.Цэдэнлхам /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн/
- Б.Эрдэнэтуяа /Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн/

2. Холбогдох хууль тогтоомж, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн заалтыг чанд сахиж, мөрдөн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 113 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Батчулуун/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБАТ

Төсөвт бүрдүүлсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээ

№	Нэгдсэн төсөвт төлсөн татвар, нийгмийн даатгал	Төсөвт бүрдүүлсэн дүн
1	ХХОАТ	7,339,872
2	АТӨЯАТ	338,648
3	Ажил олгогчийн төлсөн НДШ	9,043,983
4	Ажилчны төлсөн НДШ	8,182,651



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.10 № 05/5881
танай _____-ны № _____-г

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Булган аймгийн Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдохоор нэр дэвшсэн Банзрагчийн Одхүүгийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



ХЭВХ
Б.Орхуй
[Handwritten signature]

142303005767



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар Б/40

Булган сум

Б.Одхүүг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 21, 23, 24 дүгээр зүйл, Авилгатай тэмцэх газрын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 05/5881 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирлаар Банзрагчийн Одхүүг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга), мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд мэдүүлэхийг Б.Одхүүд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000228628

2020.03.02

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

0411011164

/ Хувийн хэргийн дугаар /

3197956

/ Регистрийн дугаар /

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

07

2020.02.19

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

01500

/ Код /

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

3,258,138.64

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Булган, Булган, 5-р баг, Жаргалант, 0, Утас1: 94279717, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/ тэмдэг /

А.РАДНААБАЯР

/ гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2021 он 10 сар 15 өдөр





МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000228628

2020.03.02

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

0411011164

/ Хувийн хэргийн дугаар /

3197956

/ Регистрийн дугаар /

Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

07

2020.02.19

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

01500

/ Код /

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

3,258,138.64

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Булган, Булган, 5-р баг, Жаргалант, 0, Утас1: 94279717, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/ тэмдэг /

А.РАДНААБАЯР

/ гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2021 он 10 сар 15 өдөр



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Шинүү овогтой Өлзийхутаг-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.03.30	А.Раднаабаяр 24/1-11
2	Дахин гэрчилгээ олгов.	2021.10.15	А.Раднаабаяр
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1031777.24 мян.төг-р хасагдаж нийт 2226361.4 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2023.05.02	А.Раднаабаяр 24/1-11
4	Банзрагч овогтой Одхүү-а Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.05.02	А.Раднаабаяр



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000226628